



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2012 оны 09 сарын 14 өдөр

Дугаар A/359

Мандалговь

Г
**Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон шинэ хаяг авсан 19 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Ж.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны A/352 дугаар захирамжийн хавсралтын 2 дахь хэсэг, 2018 оны A/59 дүгээр захирамжийн хавсралтын 303, 304, 305 дахь хэсэг, 2021 оны A/468 дугаар захирамжийн хавсралтын 375, 384, 385, 386, 462 дахь хэсэг, 2021 оны A/498 дугаар захирамжийн хавсралтын 73, 74, 80 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

4822111193